



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 480

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 83,000,000.00 /наян гурван сая/ төгрөгийн балансын үнэ, 4,841,666.69 /дөрвөн сая найман зуун дөчин нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран есөн мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг Төрийн худалдан авах ажиллагааны газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Улам-Өрнөх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА
ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ
Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
480 дугаар тогтоолын хавсралт



Үндэсний аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Төрийн худалдан авах ажиллагааны газарт балансаас
балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Соната DN-8, 01-60 УАЕ, арал№ KMHL3416BLA039755	2019/ 2019	83,000,000.00	4,841,666.69	78,158,333.31
	Нийт дүн		83,000,000.00 /наян гурван сая/	4,841,666.69 /дөрвөн сая найман зуун дөчин нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран есөн мөнгө/	78,158,333.31 /далан найман сая нэг зуун тавин найман мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин нэгэн мөнгө/